



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 25 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 25 дугаар хуралдааныг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан болно.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 25 дугаар хуралдаанаар /2025-12-10/ “Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт” зохион байгуулах тухай; “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2021 оны 02 тоот тогтоол); “Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2021 оны 23 тоот тогтоол); “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2021 оны 24 тоот тогтоол); “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-д шалгарсан оролцогчдын сонгосон радио давтамжийн зурвасыг тусгай зөвшөөрлөөр олгох тухай (Хорооны 2025 оны 245 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлогын төлөвлөгөө болон зардлын төсөл, байгууллагын 2027-2028 оны төсвийн төсөөлөл”-ийн тухай”, Үүнд: ХХЗХ-ны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2026 оны орлого, зардлын төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2026 оны хөрөнгө оруулалтын зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2026 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2026 оны үйл ажиллагааны зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2027-2028 оны төсвийн төсөөлөл”-ийн төсөл (Анхны хэлэлцүүлэг); Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, шилжүүлэх тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзаж, мэдэгдэл хүргүүлэх тухай-ИНЕГ) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 17 (Тогтоол №249-265, 2025-12-10) тогтоолыг тус тус батлан шийдвэрлэв.

Тус хуралдаанаар Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.2}, 5^{1.1.11} дэх заалт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/46 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тус тус үндэслэн “Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт”-ын танилцуулга, үндэслэл болон холбогдох сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийн төсөл, сонгон шалгаруулалтыг зарлах тухай тогтоолын төслийг

ажлын хэсгээс боловсруулсан. Ажлын хэсгийн боловсруулсан сонгон шалгаруулалтын талаар танилцуулга, ирүүлсэн хүсэлт, ажлын хэсгийн санал, дүгнэлт болон тогтоолын төсөл, сонгон шалгаруулалтын баримт бичгийн төслийг ХХЗХ-ны 2025 оны ээлжит 25 дүгээр хуралдаанаар хэлэлцээд, хорооны дарга, гишүүдээс гарсан санал зөвлөмжийг тусган 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 249 тоот “Сонгон шалгаруулалт зарлах тухай” тогтоолыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.2}, 5^{1.1.11} дэх заалт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/46 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тус тус үндэслэн баталж шийдвэрлэв. Энэхүү тогтоолд, “Тогтоолын 1 дүгээр заалтад, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр зарласугай. 2 дугаар заалтад, Энэхүү тогтоолын хавсралтаар “Сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг баталсугай. 3 дугаар заалтад, Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлгээний ажлын хэсэг байгуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ. ХХЗХ-ноос 2025 оны 249 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ХХЗХ-2025 /ДГЗҮ-СШ-04/ тоот “Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 30 хоногийн хугацаатай зарласан болно.

Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д тус хуульд нийцүүлэн тус хорооны 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 тоот тогтоолоор, орон нутгийн телевизүүд хөтөлбөрөө олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дамжуулан бусад аймаг, сумдад дахин дамжуулах боломжийг бий болгох зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулан баталж, Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөнийг тухай бүр бүртгүүлэн, мөрдөн хэрэгжүүлж байна. Зохицуулах хорооны Өргөн нэвтрүүлгийн газар, Хуулийн хэлтэс хамтран “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2021 оны 02 тоот тогтоол) танилцуулга, уулзалт хэлэлцүүлэг, ирүүлсэн саналын товчоо, нөлөөллийн шинжилгээ, нөхцөл шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, тогтоолын төслийг боловсруулан Хорооны 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 2025 оны ээлжит 25 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэв. Тус хуралдаанаар Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 250 тоот “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д өөрчлөлт оруулах тухай тогтоолыг батлав. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсгийг “Энэхүү нөхцөл шаардлагыг Зохицуулах хорооноос олгосон телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд дагаж мөрдөнө.” гэж, 1.8 дахь хэсгийг “Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад

харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээгээр зохицуулна.” гэж, 3 дугаар зүйлийн 3.25 дахь хэсгийг “Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай, хөтөлбөрийн онцлогт тохирсон хүний нөөцийг бүрдүүлсэн, мэргэжлийн инженер техникийн ажилтантай байна.” гэж, 3.27 дахь хэсгийг “Үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрөл шинээр авч, үйл ажиллагаа эхлүүлэхийн өмнө техникийн үйл ажиллагааг шалгаж жигдрүүлэх туршилтыг хоёр сараас илүүгүй хугацаанд хийнэ.” гэж, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг “Энэхүү нөхцөл шаардлагын 4.1-д заасан журам, хэмжилт, шалгалтын дүнг Зохицуулах хорооноос шаардсан тохиолдолд тухай бүр ирүүлнэ.” гэж, 4.9 дэх хэсгийг “Дууны түвшинг хянах, тохируулах чиг үүргийг холбогдох ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусган үүрэгжүүлсэн байна.” гэж тус тус өөрчлөн найруулсугай. Энэхүү тогтоолын 2 дугаар заалтад, “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6, 1.7 дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 3.3, 3.15, 3.26 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1 хэсэг, 6.5.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай. Энэхүү тогтоолын 3 дугаар заалтад, Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ. Хорооны 2021 оны 02 тоот тогтоолд өөрчлөлт оруулсан 2025 оны 250 тоот тогтоолыг ХЗДХЯ-ны (ХЗДХЯ №5060) бүртгэлд хөдөлгөөн хийлгэн бүртгүүлэх арга хэмжээг авахыг ӨНЗГ, Хуулийн хэлтэс, ХХНБД (Т.Наранмандах) нарт тус тус үүрэг болгов.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-д заасан чиг үүргийн дагуу “Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 23 тоот тогтоолоор батлан гаргаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдөр 5305 дугаартайгаар бүртгэснээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн болно. Уг нөхцөл, шаардлагад Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 15 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөнийг бүртгүүлэн, мөрдөн хэрэгжүүлж байна. ХХЗХ-ны Өргөн нэвтрүүлгийн газар, Хуулийн хэлтэс хамтран Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2021 оны 23 тоот тогтоол) танилцуулга, уулзалт хэлэлцүүлэг, ирүүлсэн саналын товчоо, нөлөөллийн шинжилгээ, нөхцөл шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, тогтоолын төслийг боловсруулан Хорооны 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 2025 оны ээлжит 25 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 251 тоот “Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д өөрчлөлт оруулах тухай тогтоолыг батлан шийдвэрлэв. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр зүйлийн 1.6 дахь хэсгийг “Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, нөхцөл шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээгээр зохицуулна.” гэж, 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсгийг “Үйлчилгээ эрхлэгч радио, телевизийн хөтөлбөрийн хуваарь, мэдээллийг үзэгч, сонсогчид хүргэх (EPG) системтэй байна.” гэж тус тус өөрчлөн найруулсугай. Энэхүү тогтоолын 2 дугаар заалтад, “Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 1.5 дахь хэсэг, 3

дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай. Энэхүү тогтоолын 3 дугаар заалтад, Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ. Хорооны 2021 оны 23 тоот тогтоолд өөрчлөлт оруулсан 2025 оны 251 тоот тогтоолыг ХЗДХЯ-ны (ХЗДХЯ №5305) бүртгэлд хөдөлгөөн хийлгэн бүртгүүлэх арга хэмжээг авахыг ӨНЗГ, Хуулийн хэлтэс, ХХНБД (Т.Наранмандах) нарт тус тус үүрэг болгов.

ХХЗХ-ны Өргөн нэвтрүүлгийн газар, Хуулийн хэлтэс хамтран “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2021 оны 24 тоот тогтоол) танилцуулга, уулзалт хэлэлцүүлэг, ирүүлсэн саналын товчоо, нөлөөллийн шинжилгээ, нөхцөл шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, тогтоолын төслийг боловсруулан Хорооны 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 2025 оны ээлжит 25 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 252 тоот “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолыг батлан шийдвэрлэв. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 6 дугаар зүйлд “6.21 Үйлчилгээ эрхлэгч нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8-д заасныг баримтлан хязгаарлалт хийх ба 18+ насны ангиллын кино, контентыг өөрийн үйлчилгээний промо сувгаар сурталчилахгүй.” гэж, 6.15 дахь хэсгийн “Үйлчилгээ эрхлэгч нь” гэсний дараа “Мэдээлэл харилцаа холбооны техникийн өрөөнд тавих шаардлага MNS 6869” гэж, 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсгийн “үйлчилгээ эрхлэгч нь” гэсний өмнө “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэх хүрээтэй” гэж тус тус нэмсүгэй. Энэхүү тогтоолын 2 дугаар заалтад, “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсгийг “Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, нөхцөл шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээгээр зохицуулна.” гэж, 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг “Олон суваг дамжуулах үйлчилгээг нийтийн интернэт (ОТТ технологи)-ээр дамжуулан хүргэхэд үйлчилгээ эрхлэх хүрээг тодорхой бүс нутгаар хязгаарлахгүй.” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг “Үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээний чанар, тасралтгүй найдвартай ажиллагааг хянах, дамжуулж буй радио, телевизийн дохионы чанар, дуу, дүрсийн үзүүлэлтийг холбогдох стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг тогтмол хянах, хэмжих, тохируулах дотоод журмыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.” гэж, 4 дүгээр зүйлийн 4.12 дахь хэсгийг “Утасгүй болон хиймэл дагуулын сүлжээгээр олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь хамрах хүрээний шаардлагыг хангаж байгаа болохыг хэрэглэгчийн өргөдөл, гомдолд үндэслэн хэмжилт хийдэг, шаардлагатай үед Зохицуулах хороонд ирүүлдэг байна.” гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг “Үйлчилгээ эрхлэгч нь тухайн улсынхаа хуулийн дагуу зөвшөөрөлтэй гадаадын радио, телевизийг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг баримтлан гэрээ байгуулан дамжуулна.” гэж, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “регистрийн дугаарыг” гэснийг “иргэний бүртгэлийн дугаараар” гэж тус тус өөрчлөн найруулсугай. Энэхүү тогтоолын 3 дугаар заалтад, “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 1.6 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.13 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1, 5.8, 5.9 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай. Энэхүү тогтоолын 4 дүгээр заалтад, Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д

үүрэг болгосугай.” гэжээ. Хорооны 2021 оны 24 тоот тогтоолд өөрчлөлт оруулсан 2025 оны 252 тоот тогтоолыг ХЗДХЯ-ны (ХЗДХЯ №5306) бүртгэлд хөдөлгөөн хийлгэн бүртгүүлэх арга хэмжээг авахыг ӨНЗГ, Хуулийн хэлтэс, ХХНБД (Т.Наранмандах) нарт тус тус даалгав.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 24 дүгээр хуралдаанаар /2025-11-28/ Хорооны 2025 оны 245 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” (Хорооны 2025 оны 216 тоот тогтоолыг хэрэгжүүлэх) тогтоолыг баталж, энэхүү тогтоолын 2 дугаар заалтад, Шалгарсан оролцогчоор радио давтамжийн зурвас сонгуулах үйл ажиллагааг эрэмбийн дагуу зохион байгуулж Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд 14 хоногийн дотор танилцуулж, шийдвэрлүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэгт даалгасан юм. Уг тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Үнэлгээний ажлын хэсгээс тогтоолд заасан эрэмбийн дагуу нэр бүхий 4 хуулийн этгээд болох Монголиан мюзик медиа ХХК, Хэмнэлт долгион медиа групп ХХК 80, Шүхэр НҮТББ, Монгол комикс ХХК-д Хорооны хуралдааны нарийн бичгийн даргын зүгээс тогтоолыг албажуулан 2025 оны 12 дугаар сарын-02-ны өдрийн 05/2396 албан тоотор мэдэгдэж, холбогдох уулзалтыг товлож “Радио давтамжийн сувгийг сонгож баталгаажуулах маягт” (маягт-9)-ын дагуу сонгуулах, баталгаажуулах арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн зохион байгуулсан болно. Тус хорооны 2025 оны ээлжит 25 дугаар хуралдаанд ажлын хэсгээс Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад ашиглах радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийг дээрх нэр бүхий 4 хуулийн этгээдэд сонголтын баталгаажуулалт дагуу олгох танилцуулга, санал дүгнэлт, тусгай зөвшөөрөл олгох тухай 4 тогтоолын төслийг тус тус боловсруулан хэлэлцүүлэв. Тус хуралдаанаар Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, тус хорооны 2025 оны 245 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 253 тоот, 254 тоот, 255 тоот, 256 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг тус тус батлав. Үүнд:

- Хорооны 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 253 тоот тогтоолын 1 дүгээр заалтад, “Монголиан мюзик медиа ХХК-д Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад 84.9 МГц-ийн радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2030 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай. Энэхүү тогтоолын 2 дугаар заалтад, Монголиан мюзик медиа ХХК нь тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай. Энэхүү тогтоолын 3 дугаар заалтад, Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.
- Хорооны 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 254 тоот тогтоолын 1 дүгээр заалтад, Хэмнэлт долгион медиа групп ХХК-д Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад 81.7 МГц-ийн радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2030 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай. Энэхүү тогтоолын 2 дугаар заалтад, Хэмнэлт долгион медиа групп ХХК нь тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан

өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай. Энэхүү тогтоолын 3 дугаар заалтад, Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.

- Хорооны 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 255 тоот тогтоолын 1 дүгээр заалтад, “Шүхэр НҮТББ-д Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад 81.3 МГц-ийн радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2030 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай. Энэхүү тогтоолын 2 дугаар заалтад, Шүхэр НҮТББ нь тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай. Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.
- Хорооны 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 256 тоот тогтоолын 1 дүгээр заалтад, “Монгол комикс ХХК-д Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад 86.9 МГц-ийн радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2030 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай. Энэхүү тогтоолын 2 дугаар заалтад, Монгол комикс ХХК нь тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай. Энэхүү тогтоолын 3 дугаар заалтад, Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.

Тус хорооны 2025 оны ээлжит 25 дугаар хуралдаанаар Даргын 2025 оны А/266 дугаар тушаалаар байгуулагдсан тус Хорооны гишүүн, ажлын албаны дарга А.Лувсан-Очирын ахалсан ажлын хэсэг, бүтцийн ажлын албанаас нэгтгэн боловсруулсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлогын төлөвлөгөө болон зардлын төсөл, байгууллагын 2027-2028 оны төсвийн төсөөлөл” (Үүнд: ХХЗХ-ны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2026 оны орлого, зардлын төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2026 оны хөрөнгө оруулалтын зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2026 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2026 оны үйл ажиллагааны зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2027-2028 оны төсвийн төсөөлөл”)-ийн төсөл (Анхны хэлэлцүүлэг)-ийн танилцуулга, байгууллагын 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, орлого, зардлын төлөвлөгөөний төслүүд, 2027-2028 оны төсвийн төсөөллийн төслийн багц баримт бичгүүдийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Тус хуралдааны үеэр хэлэлцсэн асуудлаар хорооны дарга, гишүүдээс өгсөн санал зөвлөмж, удирдамж чиглэлийг тусгах; тухайлбал, Дотоод нөөцөөр гүйцэтгэж болох ажил дээр төсөв хэмнэх; Төсвийн төлөвлөлтөд 2025 оны санхүүгийн төсвийн гүйцэтгэлийг тусгаж танилцуулах; зайлшгүй төсөв зарцуулах шаардлагатай үйл ажиллагааг эрэмбэлэх; 2025/2026 оны төлөвлөгөөтэй хийсэн харьцуулалт; бусдаар гүйцэтгүүлсэн төсөл, зөвлөх арга хэмжээний хүрсэн үр дүнг тодорхой болгох; 2025 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр төсөв, зардлыг гаргах; 2026 оны хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын томоохон хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр, гадаад арга хэмжээний төлөвлөлт, төлөвлөлтийг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлтийн аргачлал, бүтцийн нэгж, газар хоорондын уялдаа холбоог сайжруулах, ач холбогдлоор эрэмбэлэх; өөрсдийн дотоод

нөөц бололцоог ашиглах, төлөвлөсөн зарим үйлчилгээ, арга хэмжээний төсөв зардлыг оруулах эсэх талаар дахин авч үзэх; 2026 оны төсөвт Орбит станцад баригдах албан байрны ТЭЗҮ боловсруулах, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хэмжээний холбогдох зардлыг тусгах; баталгаажуулалт, радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийг тооцох аргачлалд шинэчлэлт хийх; хорооны санхүүгийн нөөц, чадварыг дээшлүүлэх талаар арга хэмжээг тусган боловсруулах, хорооны хуралдаанд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх, энэхүү асуудлыг багцаар нь хуралдаанд дахин хэлэлцүүлэх, батлуулах арга хэмжээ авч ажиллахыг Ажлын хэсэг (А.Лувсан-Очир)-т болон холбогдох бүтцийн нэгжийн газар, хэлтсийн удирдлага нарт үүрэг болгох нь зүйтэй гэж тогтов.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 25 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, шилжүүлэх тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзаж, мэдэгдэл хүргүүлэх тухай (ИНЕГ) ажлын хэсгийн санал, дүгнэлт болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 9 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 9 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 257 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Эс Ти окмээдани ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс –БНСВУ/) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 258 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 2 хуулийн этгээдэд 2 тусгай зөвшөөрлийг (Нэт эра линк ХХК, Идэр нэтворкс ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10, 14 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 259 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг (Дижитал повер ХХК, 12100658 тоот; Моннис инженеринг ХХК, 12100661 тоот : Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 260 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Сансар дижитал ХХК: Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” (574-606 МГц) 23410031 тоот тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгасан;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 261 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Монгол контент ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх” 11300012 тоот тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 3.8 дахь хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 262 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөлд (Трионикс мета вишн ХХК-ийн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх” 12900351 тоот тусгай зөвшөөрлийн “Попкорн ТВ” телевизийн нэрийг “Бантан ТВ” болгох) өөрчлөлт оруулсан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 19 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 263 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Монголиан ньюс чаннел ХХК-ийн Монгол Улсын нутаг дэвсгэрт “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх” 12900048 тоот тусгай зөвшөөрлийг Лэйди чаннел ХХК-д) шилжүүлсэн;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 264 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд (Таван уул групп ХХК: 1800-8888) 1 харилцаа холбооны сүлжээний дугаарыг 2 жилийн хугацаагаар олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 265 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдэд олгосон (Эйр транс ХХК: 1800-1900; Улаанбаатар телевиз ХХК: 1900-1951) 2 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилээр сунгаж тус тус шийдвэрлэв.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 25 дугаар хуралдаанд тусгай зөвшөөрлийн тухай асуудлын хүрээнд ажлын албанаас ИНЕГ-аас “13600122 тоот тусгай зөвшөөрлийг Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК-д шилжүүлэх” тухай хүсэлтийн талаар ажлын албаны болон хууль эрхзүйн дүгнэлт, хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзах тухай албан мэдэгдлийн төслийг тус тус танилцуулав. Энэхүү асуудлаар, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 19, мөн хуулийн 5.2 дугаар зүйлийн 9-д заасныг тус тус үндэслэн хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзсан тухай Ажлын албаны дүгнэлтийг дэмжиж, албан мэдэгдлийг Хорооны даргын гарын үсэгтэй албажуулан хүргүүлэхээр тогтов.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-12-15